



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 9 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 270

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12.1.3, 12.1.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран баталж, хэрэгжилтийг төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурлан мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын үүрэг гүйцэтгэгч Н.Номтойбаяр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч Г.Чулуунбаатар, Эрүүл мэндийн сайдын үүрэг гүйцэтгэгч А.Цогцэцэг нарт даалгасугай.
3. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг эрхэлсэн салбар болон харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын үүрэг гүйцэтгэгч Н.Номтойбаярт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын
үүрэг гүйцэтгэгч

Ж.ЭРДЭНЭБАТ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын үүрэг гүйцэтгэгч

Н.НОМТОЙБАЯР

Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт

ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын хүн ам 2016 онд 3,119,935 болж өссөн бөгөөд нийт хүн амын 37,6 хувь буюу 1,173,918 нь 0-18 насны хүүхэд байна. Монгол Улсын Засгийн газраас манай улсын нийт хүн амын гуравны нэгийг эзэлж байгаа хүүхдийн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах, сурч боловсрох, хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн бодлогыг байнга хэрэгжүүлж ирсэн бөгөөд үндэснийн хууль тогтоомжийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протокол, "Хүүхдийн амьдралд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглалын зарчим, үзэл санаанд нийцүүлэх, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас хүүхдийн эрхийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр дүнг Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийн 5 дахь тайлангийн үнэлгээгээр тооцож үзэхэд багагүй амжилт үзүүлсэн байна. Тухайлбал, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1990 оны түвшинтэй харьцуулахад 4 дахин буурсан, 5 хүртэлх насны хүүхдийн өсөлтын хоцролт 2000 онд 33 хувь байсан бол 2013 онд 10.8 хувь болж буурсан, сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн эзлэх жин 79.2 хувьд, бага болон дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин тус бүр 97 хувьд тус тус хүрсэн байна.

Сүүлийн жилүүдэд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хэд хэдэн хууль батлагдан хэрэгжиж эхлээд байна. Тухайлбал, Улсын Их Хурлаас 2015 онд Хүүхэд харах үйлчилгээний тухай, 2016 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг баталсан. Мөн Улсын Их Хурлаас 2015 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэргийг бие даасан бүлэг болгон, 2016 онд шинэчлэн баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалтуудыг тус тус хуульчилсан. Эрх зүйн шинэчлэлийн дунд хүүхдийг нийгмийн бүх орчинд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас ангид байлгах, тэдний хамгаалагдах эрхийг хуулиар баталгаажуулснаар манай улс хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх орчинд хуулиар хориглосон дэлхийн 49 дэх орон болсон.

Манай улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх 5 дугаар тайлан илтгэлийг 2017 оны 5 дугаар сард НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 75 дугаар чуулганаар хэлэлцүүлэн зөвлөмж хүлээн авсан бөгөөд энэ удаагийн зөвлөмж нь хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарахыг чухалчилсан байна.

Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаарх хууль, эрх зүйн орчин сайжирч, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж, тодорхой үр дүн гарч байгаа хэдий ч тулгамдаж байгаа шийдвэрлэх асуудал байсаар байна.

Хүүхдийн өвчлөл, эндэгдэл тогтвортой буурахгүй, зарим бус нутаг, аймагт эх, хүүхдийн эндэгдлийн харьцаа өндөр байна. Сүүлийн таван жилд улсын хэмжээнд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 18.6, хөдөө орон нутагт 20.5. Улаанбаатар хотод 16.8 байна. Сүүлийн таван жилд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд перинатал үед үүссэн эмгэг 44.7 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 15.8, осол гэмтэл 13.3 хувь, нярайн эндэгдлийн шалтгааны 9.6 хувийг төрөлхийн хөгжлийн гажиг эзэлж байна.

Улаанбаатар хот, зарим аймгийн төвд хүн амын төвлөрөл ихсэж, тэдгээрийн дийлэнх нь гэр хороололд амьдарч байгаагийн улмаас хүүхэд агаарын бохирдоос үүдэлтэй амьсгалын замын өвчинд өртөх нь ихсэж байна. Улаанбаатар хотын хүүхдүүд агаарын бохирдол багатай хот, суурингийн хүүхдүүдтэй харьцуулахад амьсгалын эрхтний өвчнөөр 7-8 дахин илүү өвчилж байна. Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2016 оны тоон мэдээгээр 5 хүртэлх насны хүүхдийн осол гэмтлийн шалтгаант нас баралт хүүхдийн нийт нас баралтын 14.4 хувийг эзэлж байгаа бөгөөд түүний 76.5 хувь нь түлэгдэлтийн улмаас нас барсан байна. Түлэгдсэн шалтгаанаар нас барсан хүүхдүүдийн 77 хувь нь халуун хоол, цайнд, 23 хувь нь халуун усанд түлэгдсэн байгаагаас үзэхэд эцэг, эх, асран хамгаалагчаас хүүхдэд тавих анхаарал, халамж хангалтгүй байгааг харуулж байна.

Бага насны хүүхдэд үзүүлэх хөгжлийн үйлчилгээний хүртээмж бага байна. Улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 3-5 хүртэл насны хүүхдүүдийн ердөө 68 хувь нь, хөдөө орон нутагт 57 хувь хамрагдаж байна. Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин жендэрийн ялгаагүйгээр бараг 100 хувьд хүрсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнхийн хүүхдийн сургуульд хамрагдант бага, тэгш хамруулан сургах арга зүй, хандлага сул байна. Сургууль, цэцэрлэг, хүүхэд хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, төвийн материаллаг бааз, сургалтын хэрэглэгдэхүүн дутагдалтай, орчин хангалтгүй байсаар байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гарсаар л байна. Тухайлбал, 1-14 насны хүүхдийн 47 хувьд сахилга, хүмүүжлийн арга хэмжээг авахдаа хүчирхийлийн арга хэрэглэснийг судалгаагаар тогтоосон байна. Хүүхдүүд интернэт ашиглах боломж нэмэгдэхийн хэрээр цахим орчин дахь доромжлол, сэтгэл санааны болон бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэл нэмэгдэж байна. Төвлөрсөн халамж, асрамжийн газарт байгаа хүүхдийн тоо буурсан ч тэднийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, гэр бүлдээ амьдрахад нь дэмжлэг үзүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах явдлыг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, хүний болон санхүүгийн нөөц бүхий хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна.

Үндэсний статистикийн хорооноос хийсэн "Хүүхдийн олон хэмжээст, давхацсан гачигдлын шинжилгээ"-ний дүнгээс харахад 0-23 сартай дөрвөн хүүхэд тутмын нэг нь (25.9 хувь) нэгэн зэрэг турван төрлийн гачигдалд өртөж байна. Энэ насны хүүхдийн 13.7 хувь нь хоол тэжээл, усан хангамж, ариун цэврийн байгууламжийн гачигдалд нэгэн зэрэг, харин 24 хувь нь хоол тэжээл, ариун цэврийн байгууламжийн гачигдалд тус тус өртөж байна. Түүнчлэн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээс үзэхэд хүүхдүүд орлогын ядууралд өртсөөр байна. Нийт хүүхдийн 28.9 хувь нь ядуу ерхөд амьдарч байгаа бөгөөд здгээр хүүхэд нь ядуурлын шугамаас доогуур амьдарч

байгаа хүмүүсийн 46 хувийг бүрдүүлж байна. Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцоо олон жилийн туршлагатай ч түүнийг гэр бүл, хүүхдэд ээлтэй, үр нөлөөтэй, тогтвортой байдлыг хангах шаардлагатай байна.

Дээр дурдсан тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор Засгийн газраас 1992-2002, 2002-2010 онуудад Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн амжилт, сургамж, туршлагадаа үндэслэн Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг боловсрууллаа.

Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2016-2020)-т хүүхдийн хөгжил, хамгаалал, эрүүл мэнд, боловсролын талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Хөтөлбөрийн зорилго

Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бусад салбарын оролцоотойгоор бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж байна:

2.2.1. хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.

2.2.2. хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлнэ.

2.2.3. хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.2.4. нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаална.

2.2.5. тэгш боломж олгох нийгмийн хамгааллыг дэмжих замаар хүүхдийн орлогын болон орлогын бус ядуурлыг бууруулна.

2.3. Хөтөлбөрийг 2017-2021 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Хөтөлбөрийн "хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхдэд зэлтэй орчныг бүрдүүлэх" 1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. хүүхдэд зэлтэй эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, хүүхдийн сэргийлж болох өвчлөл, эндэгдлийг бууруулах чиглэлээр;

3.1.1.1. эх, нярай болон 5 хүртэлх насын хүүхдэд нэн шаардлагатай эрүүл мэндийн багц тусlamжийн хамралтыг нэмэгдүүлэх;

3.1.1.2. товтолт болон сайн дурын дархлаажуулалтад 5 хүртэлх насын хүүхдийн хамралтыг нэмэгдүүлэх;

3.1.1.3. хүүхдийн сэргийлж болох өвчин, эндэгдэлд (хатгалгаа, сүрьеэз, суулгалт, осол гэмтэл зэрэг) нөлөөлөх хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Засаг даргын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх;

3.1.1.4. хүүхэд бүрийг бодисын солилцооны эмгэг, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд тогтмол хугацаанд хамруулах;

3.1.1.5. хөдөөгийн болон орлого багатай өрхийн хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авч, нэн шаардлагатай амин дэмээр хангах, амин дэм түгээх явцад хоол тэжээлийн зөвлөгөө өгөх ажлыг хавсран явуулах;

3.1.1.6. хүүхдийн шүдний цоорол, өвчлөлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж, хүүхдийн шүдний эмчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх;

3.1.1.7. цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд хяналт тавих ажлыг эцэг, эхийн оролцоотой зохион байгуулах;

3.1.1.8. хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүнсний бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээг сургууль, цэцэрлэгийн орчинд хориглох.

3.1.2. өсвөр үеийнхэнд зэлтэй эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг өргөжүүлж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

3.1.2.1. ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт эрүүл мэндийн хичээлийг тусгах;

3.1.2.2. өсвөр үеийнхэнд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжиж, эрүүл амьдралын хэв маягт төлөвшүүлэх;

3.1.2.3. нөхөн үржихүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг аймаг, дүүргийн түвшинд бэхжүүлэх;

3.1.2.4. ерөнхий боловсролын сургуульд эмч, сэтгэл зүйч ажиллуулж, хүүхэд, өсвөр үеийнхний хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх;

3.1.2.5. багш, эмч, нийгмийн ажилтан, сайн дураар ажиллах оюутан, залуучуудыг нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүлийн болон бэлгийн боловсрол олгох сургагч багшаар бэлтгэх;

3.1.2.6. дэлгэцийн донтолт, архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, хүчирхийлэл, дарамт, шахалт, эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

3.1.2.7. өсвөр үеийнхний эрүүл мэндийн үзүүлэлтийг гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх.

3.1.3. эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтэд хүүхдийг асрах, хүмүүжүүлэх мэдлэг, хандлага төлөвшүүлэх чиглэлээр:

3.1.3.1. хүүхдэд зонхилон тохиолдох өвчин, эмгэгээс сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах;

3.1.3.2. Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийг сурталчлах, хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжихэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх;

3.1.3.3. хүүхдийг насын онцлогт нь тохируулан асрах, хүмүүжүүлэх мэдлэг, хандлагыг эцэг, эх, асран хамгаалагч нарт төлөвшүүлэх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах;

3.1.3.4. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийг хүүхдээ асрах, сэргээн засах, хөгжүүлэх чиглэлийн сургалтад үе шаттай хамруулах.

3.1.4. хүүхдэд зэлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлж, нийгмийн хариуцлагыг төлөвшүүлэх чиглэлээр:

3.1.4.1. боловсролын болон хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад тавигдах эрүүл ахуйн болон үйлчилгээний стандартыг шинэчлэн баталж мөрдүүлэх;

3.1.4.2. хүүхдийн хувцас, тоглоом, хичээлийн хэрэгсэл, сургалтын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, худалдаанд тавих хяналтыг иргэдийн оролцоотойгоор сайжруулах;

3.1.4.3. хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын хариуцлагыг нэмэгдүүлэх сурталчилгааний ажлыг өрнүүлж, санамж, сээрэмжлүүлэг түгээх;

3.1.4.4. агаарын бохирдлын улмаас хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх серөг нөлөөг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэх;

3.1.4.5. эрүүл мэндийн болон боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтэд "Хүүхдэд ээлтэй эмнэлэг", "Эрүүл мэндийг дэмжигч сургууль"-ийн үзүүлэлтийг тусгах.

3.2. Хөтөлбөрийн "хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх" 2 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, эцэг эх, олон нийтийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:

3.2.1.1. бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаанд үнэлгээ хийж, зөвлөмж гаргах, гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх;

3.2.1.2. бага насны хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих чиглэлээр бий болсон сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, эцэг эхийн чадавхыг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог сайжруулах;

3.2.1.3. хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлсийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх;

3.2.1.4. хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэн хөгжүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх;

3.2.1.5. сургуулийн өмнөх насны бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулж сургуульд бэлтгэх;

3.2.1.6. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суурь боловсролд тэгш хамруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.2.1.7. тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулах;

3.2.1.8. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд хүүхдийн хөгжлийг дэмжих асуудлыг тусгах, уг үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, төсөв, хяналтын тогтолцоог оновчтой болгох;

3.2.1.9. хүүхдэд байгаль орчноо хайрлах, үндэсний өв уламжлал, соёл, ёс заншлаа мэдэх, хүндэтгэх, суралцахад чиглэсэн үйл ажиллагааг үндэсний болон

орон нутгийн музей, номын сан, хэвлэл мэдээлэл, соёл, урлагын байгууллага, түүхч, эрдэмтэн, ахмад настан, алдар гавьяат хүмүүсийн оролцоотой зохион байгуулах;

3.2.1.10. тэр хороололд хүүхдийн тоглоомын талбай, чөлөөт цагийн төв байгуулах, тохижуулах, засварлах талаар санаачилга гаргаж байгаа иргэн, байгууллагыг дэмжих, олон нийтэд сурталчлах.

3.2.2. хүүхдэд чиглэсэн сургалт, хөгжүүлэх ажлын нэр төрлийг нэмэгдүүлэх, чанар, хүртээмжийг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр:

3.2.2.1. сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагаа, сургалтын чанар, хүртээмж, үнэ төлбөрийн байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах;

3.2.2.2. хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн хүртээмж, сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.2.2.3. хүүхдийн зусландаа хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төслийг шалгаруулж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх;

3.2.2.4. урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив, дэлхийн чанартай уралдаан, тэмцээнд оролцох болзол хангасан болон амжилт гаргасан хүүхдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулалт олгох эрх зүйн орчинд үнэлгээ хийж, ялгавартай байдлыг арилгах арга хэмжээ авах;

3.2.2.5. хүүхдийн санаачилсан шинэ бүтээлийг дэмжих, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх;

3.2.2.6. цахим тоглоомын газар, интернет төвүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгальт хийж, хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэл зүй, хүмүүжилд нь сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа газар, төвийн үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авах;

3.2.2.7. зарим аймаг, дүүрэгт хүүхдийн хөгжлийн ордон, хүүхэд хамгааллын үйлчилгээний төв байгуулах, барих, өргөтгөл хийхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх.

3.3. Хөтөлбөрийн "хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх" З дугаар зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. хүүхдийн оролцоог дэмжих талаар эцэг эх, асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтны ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, клуб, бүлгийн санал, санаачилгыг дэмжих чиглэлээр:

3.3.1.1. хүүхдэд нөлөөлөх аливаа асуудлыг шийдвэрлэх явцад тэдний үзэл бодлыг харгалзан үзэх, үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох хандлагыг эцэг, эх,

асран хамгаалагч болон багш, нийгмийн ажилтанд төлөвшүүлэх сургалт, нэлөөллийн ажлыг зохион байгуулах;

3.3.1.2. эрсдэлт нөхцөлд байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд орон нутгийн болон үндэсний хэмжээнд зохион байгуулагдах хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх;

3.3.1.3. сургууль, орон нутгийн болон үндэсний түвшинд бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог хангаж тэдний санал, санаачилгыг дэлжин ажиллаж байгаа сайн туршлагыг дэлгэрүүлэх;

3.3.1.4. хүүхдийн болон тэдний төлөөллийн байгууллагын саналыг сонсох, хүүхэд тэднийг төлөөлөх хууль ёсны талуудын өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэх боломжийг өргөжүүлж шийдвэрлэлтэд хяналт тавих;

3.3.1.5. хүүхэд, өсвөр үеийнхэнд өөрийгөө илэрхийлэх, бусдыг хүндлэх, маргаан, зөрчлийг эв зүйгээр зохицуулах ёс суртахууныг төлөвшүүлэх, нийгмийн харилцааны чадварт сургах арга зүй боловсруулж цэцэрлэг, сургуулиудад хэрэгжүүлэх.

3.3.2. хүүхдийн нөхцөл байдлын талаарх судалгааг сайжруулах, хүүхдэд зориулсан мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

3.3.2.1. хүүхдийн эрхийн мэдээллийн сан бүрдүүлж, хүүхдэд тулгамдсан асуудлын талаар судалгаа хийж гаргасан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх;

3.3.2.2. эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг нас, хүйс, газар зүйн байршил, нийгэм, эдийн засгийн байдал зэрэг үзүүлэлтээр гаргаж, дүн шинжилгээ хийх, гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх;

3.3.2.3. хүүхдийн нийгэм, оюун санаа, ёс суртахуун, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг дэмжсэн контентийг дэмжих, хүүхдэд зориулсан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэх;

3.3.2.4. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, түүний нэмэлт протокол, зөвлөмж болон холбогдох хууль тогтоомжийг хүүхдэд ойлгомжтой хэлбэрээр хялбаршуулан хэвлэж түгээх, энэ чиглэлээр сургалт зохион байгуулах.

3.4. Хөтөлбөрийн "нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлэгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаалах" 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.4.1. хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр:

3.4.1.1. хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэх, түүнд учрах эрсдэл, хор нөлөөнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Хүүхэд хамгааллын жишиг баримт бичиг"-ийг баталж мөрдүүлэх;

3.4.1.2. эцэг эх, асран хамгаалагч болон багш, сурган хүмүүжүүлэгчдэд хүүхэдтэй ажиллах эв дүй, хүмүүжлийн зерэг арга, хандлагыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах;

3.4.1.3. хүүхдийн асрамж, халамжийн болон хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдаж байгаа, дотуур байр, сүм, хийдэд амьдардаг болон үрчлэгдсэн хүүхдийн амьдрах орчинд нөхцөл байдлын үнэлгээ хийх ажлыг тогтмол хугацаанд зохион байгуулах;

3.4.1.4. хүүхдийн аюулгүй, халдашгүй байдлыг хангах зорилгоор цэцэрлэг, сургууль, дотуур байр, хүүхдийн асрамж, халамжийн төв, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчийн байр, мөрдөн байцаалтын өрөө, саатуулах болон цагдан хорих байр, хорих ангид камерын хяналтын системийг бүрэн нэвтрүүлэх.

3.4.2. хүүхэд нийгмийн бүх орчинд хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэх, эрсдэлд ойр байгаа, эсхүл эрсдэлд өртсөн хүүхэд, гэр бүлд үзүүлэх тусламж, үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр:

3.4.2.1. хүүхэд хамгааллын үйлчилгээний багцыг тодорхойлж, үйлчилгээний зардал тооцох аргачлал гарган үйл ажиллагаандaa ашиглах;

3.4.2.2. хүүхдийн асрамж, халамжийн төвлөрсөн үйлчилгээг хувилбарт үйлчилгээнд үе шаттайгаар шилжүүлж, холбогдох журам, стандартыг батлан мөрдүүлэх;

3.4.2.3. хараа хяналтгүй хүүхдийн нөхцөл байдал, гудамжинд гарахад нөлөөлж байгаа шалтгааныг судалж, гэр бүлд нь нэгтгэх ажлыг зохион байгуулах;

3.4.2.4. хараа хяналтгүй хүүхдийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах;

3.4.2.5. гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, сэжигтэн, мөрдөн шалгагдаж байгаа, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, шүүхээр шийтгэгдсэн хүүхдэд хууль зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах;

3.4.2.6. гамшигийн үед хүүхдийн эрхийг хамгаалах, тэдэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх, сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагад гамшигаас хамгаалах дадлага, сургуулиалтыг тогтмолжуулах.

3.4.3. хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, зан суртахуунд сергөөр нөлөөлөх хөдөлмөрийг хориглох чиглэлээр:

3.4.3.1. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн талт хэлэлцээрт “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдүүлэх асуудлыг тусгаж хэрэгжүүлэх;

3.4.3.2. хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг устгах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.4.3.3. хурдан морины өвөл, хаврын уралдаанд 16-аас доош насын хүүхэд оролцохыг хориглох, зөвшөөрөгдсөн уралдааны үед хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах асуудлыг хуульчлах.

3.4.4. хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж байгаа байгууллагын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр:

3.4.4.1. хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сургалтын модуль, үйлчилгээний арга зүй боловсруулж хэрэгжүүлэх;

3.4.4.2. боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хууль сахиулах салбарын болон хүүхдийн байгууллагын ажилтнуудад зориулсан хүүхдийн эрх, хамгааллын сургалтыг тогтмол хугацаанд зохион байгуулж хэвшүүлэх;

3.4.4.3. орон нутгийн Хамтарсан баг, бүх шатны Засаг даргын дэргэдэх Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, гишүүдийг хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх;

3.4.4.4. хүүхдийн эрхийн улсын байцаагчийг бэлтгэх, эрх олгох, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

3.4.4.5. дотуур байрны багшийг нийгмийн ажлын чиглэлээр үе шаттай мэргэшүүлэх, ажлын байрны тодорхойлолтод хүүхдэд нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар тусгах;

3.4.4.6. боловсролын байгууллагад ажиллаж байгаа нийгмийн ажилтныг сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх чиглэлээр мэргэшүүлэх;

3.4.4.7. эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа сайн дурын ажилтнуудыг дэмжих, урамшуулах;

3.4.4.8. хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн этгээдийн зан үйлийг өөрчлөх сайн дурын болон албадан сургалтыг тогтмол зохион байгуулах.

3.5. Хөтөлбөрийн “тэгш боломж олгох нийгмийн хамгааллыг дэмжих замаар хүүхдийн орлогын болон орлогын бус ядуурлыг бууруулах” 5 дугаар зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.5.1. хүүхдийн ядуурлыг орлогын болон орлогын бус үзүүлэлтээр хянаж, хариу арга хэмжээ авах чиглэлээр:

3.5.1.1. хүүхдийн орлогын болон орлогын бус ядуурал, түүний үр дагаврын талаарх олон нийт, холбогдох байгууллага, мэргэжилтний ойлголтыг нэмэгдүүлэх;

3.5.1.2. хүүхдийн орлогын болон орлогын бус ядуурлын байдалд дүн шинжилгээ хийх;

3.5.1.3. ядуурлыг бууруулах үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрт хүүхдийн ядуурлыг бууруулах асуудлыг тусгах.

3.5.2. нийгмийн хамгааллын бодлогыг гэр бүл, хүүхдэд ээлтэйгээр хэрэгжүүлэх чиглэлээр:

3.5.2.1. нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрт үнэлгээ хийж, гэр бүл, хүүхдэд чиглэсэн арга хэмжээ, үйл ажиллагааг нэмэгдүүлэх талаар зөвлөмж гаргаж хэрэгжүүлэх;

3.5.2.2. нийгмийн хамгааллын гэр бүл, хүүхдэд ээлтэй олон улсын туршлагыг судлах;

3.5.2.3. гэр бүл, хүүхдэд ээлтэй нийгмийн хамгааллын бодлого хэрэгжүүлэх санхүүжилтийг нэмэгдүүлэх талаар нотолгоонд сууриссан нөлөөллийн ажил зохион байгуулах.

3.5.3. хүүхдийн аж байдалд хотжилтоос үүдэлтэй сөрөг нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлийг бууруулах чиглэлээр:

3.5.3.1. турван ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийг хоёр ээлжтэй болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;

3.5.3.2. гэр хорооллын сургууль, цэцэрлэгт агаар шүүгчийн хэрэглээг нэмэгдүүлэх, дулааны алдагдлыг бууруулах асуудлыг аж ахуйн нэгж, иргэдийн оролцоотой шийдвэрлэх аян зохион байгуулах;

3.5.3.3. гэр хорооллын гудамжийг гэрэлтүүлэх, камержуулах ажлыг үе шаттай зохион байгуулах;

3.5.3.4. сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, бохирын цооногийг стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх;

3.5.3.5. сургууль, цэцэрлэг, хүүхдийн эмнэлэг болон хүүхдийн сургалт, үйлчилгээний байгууллагын барилгын дотоод заслын материал хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх стандартын шаардлагыг тогтоож мөрдүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

4.1.1. хүүхэд бүр гэр бүлдээ эцгээ хийн хайр халамжид эрүүл энх ёсч, хүмүүжиж төлөвшиг боломж бүрдэж, эцгээ эх, асран хамгаалагч болон багш сурган хүмүүжүүлэгч, иргэдийн хүүхдэд тавих анхаарал, халамж, үүрэг хариуцлага нэмэгдэнэ.

4.1.2. хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлсэн, хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн хүүхдэд ээлтэй орчин бүрдсэн байна.

4.1.3. хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн болон хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна.

4.1.4. хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх хандлага төлөвшиж, сургууль, орон нутгийн болон үндэсний түвшинд хүүхдийн оролцоо бодитой хэрэгжих боломж бүрдэнэ.

4.1.5. нийгмийн хамгааллын бодлогыг хүүхэд, гэр бүлд ээлтэйгээр хэрэгжүүлэх хандлага төлөвшиж, хүүхдийн ядуурал буурсан байна.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь тувшин		Зорилтот тувшин				Эх сурвалж	Хэрэгжүүлэх байгууллага				
		Он	Үзүүлэлт	он	үзүүлэлт	он	үзүү- лэлт						
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт													
Зорилго: Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бусад салбарын оролцоотойгоор бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.													
Сэргийлэх боломжтой өвчлөлөөс шалтгаал- сан хүүхдийн эндэгдэл	Нийт эндэгд- лийн дотор эзлэх хувь	2016	16 (1625 тохиол- дол)	2019	14	2021	13	Эрүүл мэндийн үзүүлэлт	ЭМЯ				
Хүүхдийн өсөлтийн хоцрогдол	Түвшин	2013	10.1	2019	8	2021	7	Хоол тэжээлийн үндэсний судалгаа	ЭМЯ				
Боловсро- лын хамран сургалтын цэвэр жин	-СӨБ-ын хамран сургалт -ЕБС-ийн хамран сургалт	2015 / 2016 Хич. жил	80.9 91.2	2019	84.0	2021	85.6 94.3	УСХ, БСШУСЯ	БСШУСЯ				
Хүүхдийн хөгжлийн үнэлгээ	-Бага нас: 18 болон 36 сар -Өсвөр үеийнхэн: 11 болон 15 нас	2017	Шинээр тооцно.	2019	Тооц- сон үзүүлэл тээс нэмэгд- сэн байна	2021	Тооц- сон үзүүлэл тээс нэмэгдс эн байна		ЭМЯ, БСШУСЯ, ХХХЯ				
Хүүхдийн эрх, хам- гааллын	тоо	2016	76	2019	76<	2021	76<	-ЦЕГ-ын мэдээ -Хамтарсан	ЦЕГ, ГБХЗХГ				

зэрчлийн мэдээлэл Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд	Хувь		3.5		5.5		7.5	багийн мэдээ -108 утасны үйлчилгээнд хандсан тоо
Хүүхдийн ядуурал	Ядуурлын шугамаас доогуур орлоготой өрхед амьдарч байгаа 0-17 наасны хүүхдийн хувь	2016	28.9	2019	25	2021	20	ҮСХ ӨНЭЗС

Үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Зорилт 1: Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхдэд эзлтэй орчныг бурдуулна

5 хүртэлх насын хүүхдийн осол гэмтлээс шалтгаалсан эндэгдэл	түвшин	2016	12.7 (207 тохиолдол)	2019	11	2020	10	Эрүүл мэндийн үзүүлэлт	ЭМЯ
Хүүхдэд эзлтэй байгууллага	-Хүүхдэд эзлтэй эмнэлгийн эзлэх хувь -Өсвөр үеийнхэнд эзлтэй клиник	2016	75 (189 эмнэлэг) 28	2019	78 28<	2021	80	ЭМЯ-ны тайлан	ЭМЯ

Зорилт 2: Хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бурдуулж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлнэ

Боловсролын хувьд гачигдалтай хүүхдийн эзлэх хувь	хувь	2016	14.9 (6-14 насын хүүхдийн дунд) 6.3 (15-17 насын хүүхдийн дунд)	2019	13.0	2021	10	Хүүхдийн орлогын болон олон хэмжээст ядуурлын дүн шинжилгээ	БСШУСЯ
Хичээлээс гадуурх үйл ажиллаагаанд хамрагдсан	хувь	2018	Шинээр тооцно	2019	Тооцсон үзүүлэл тээс нэмэгдсэн Байна	2021	Тооцсон үзүүлэл тээс нэмэгдсэн Байна	БСШУСЯ	БСШУСЯ

Хүүхдийн хувь Бага боловсро-лын тэгсэлтийн бохир жин	Хувь	2015 / 2016	95.8	2019	112	2021	123.9	ҮСХ БСШУСЯ	БСШУСЯ ГБХЗХГ
Суурь боловсро-лын тэгсэлтийн бохир жин	Хувь	2015 / 2016	118.9	2019	128	2021	133.5	ҮСХ БСШУСЯ	БСШУСЯ ГБХЗХГ

Зорилт 3 Хүүхдний сансох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төвлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлнэ

Хүүхдийн веериин удирдла гын байгууллагад хамрагдаж байгаа хүүхдийн зэлэх хувь ¹	Хувь	2015	74.4 (давхардсан тоогоор)	2019	78	2021	80	ГБХЗХГ	ГБХЗХГ
Хүүхдийн саналыг шийдвэртээ тусгасан нутгийн захиргааны байгууллагын шийдвэрийн хувь ²	Хувь	2015	4.6	2019	8	2021	10	ГБХЗХГ	ГБХЗХГ
Хүүхдээс хүлээж авсан өргөдөл, гомдолын шийдвэрлэлт	-Хүүхдээс ирүүлсэн нийт өргөдөл, гомдол, хүсэлтийн шинидвэр лэлтийн хувь	2015	86.7	2019	92	2021	95	ГБХЗХГ	ГБХЗХГ

Зорилт 4 Нийгминиin бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл мөлжлэгийн бүхэлбэр, эрсдэлд нохцэлд ортөхөөс хамгаална

Хүүхэд хамгааллын үйлчилгээнд тэсвээс олгосон хөрөнгө (сая төгрөгийр)	Улсын 2016	12.8	2019	236.0	2021	300.0	ХНХЯ	ХНХЯ СЯ ГБХЗХГ
---	------------	------	------	-------	------	-------	------	----------------

Хүүхэд хамгааллын үйлчилгээнд тэсвээс олгосон хөрөнгө (сая төгрөгийр)	Улсын 2016	12.8	2019	236.0	2021	300.0	ХНХЯ	ХНХЯ СЯ ГБХЗХГ
---	------------	------	------	-------	------	-------	------	----------------

жилт										
Сэтгэл зүйн болон бие махбодийн шинтгэл	-сэтгэл зүйн шинтгэл хүлээсэн 1-14 насны хүүхдийн эзлэх хувь -бие махбодийн шинтгэл хүлээсэн 1-14 насны хүүхэд	2013	40.3	2019	35.3%	2021	30.3	Нийгмийн түүвэр судалгаа	ГБХЗХР	
				27.8		22.8%				
Зорилт 5: Тэгш боломж олгох нийгмийн хамгааллыг дэмжих замаар хүүхдийн орлогын болон орлогын бус ядуурлыг бууруулна										
Орон байр гачигдалтай хүүхдийн эзлэх хувь	0-2 нас 3-5 нас 6-14 нас 5-17 нас	2016	32 78 38 15	2019	27 67 32 13.5	2021	24 60 29 11	Хүүхдийн орлогын болон олон олон хэмжээст ядуурлын дун шинжилгээ	БХЬЯ, аймаг, нийслэлийн газрын харилцаа хот байгуулалтын газрууд	
Ариун цэврийн байгууламж гачигдалтай хүүхдийн эзлэх хувь	0-2 нас 3-5 нас 6-14 нас 15-17 нас	2016	77 76 13 12	2019	67 67 11.8 10.8	2021	58 57 10 9	Хүүхдийн орлогын болон олон олон хэмжээст ядуурлын дун шинжилгээ	БХЬЯ, аймаг, нийслэлийн газрын харилцаа, хот байгуулалтын газрууд	
Хүүхдэд эзлэтийн нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх хувь	хувь	2014	3.4	2019	4.1	2021	4.4	НҮБХС-ийн захиалгат судалгаа	СЯ, Үндэсний хөгжлийн газар	

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1 улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. олон улсын байгууллага болон хандивлагч орны зээл, тусlamж.

5.1.3 төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусlamж,

5.1.4. бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдлага зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

6.2. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг бүх шатны Засаг дарга холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

6.3. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, хэрэгжилтийн дүнг хэлэлцэж, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн идэвх санаачилгыг дэмжиж хамтран ажиллана.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран жил бүр хийнэ.

7.2. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг бүх шатны Засаг дарга холбогдох байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран жил бүр хийнэ. Бүх шатны Засаг дарга хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор хүргүүлнэ.

7.3. Хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг дараа оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

-- оОо --